



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2022 оны 2 сарын 22 өдөр

Дугаар 77

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгөд хамаарах эд хөрөнгө  
олж авах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь хэсэг, 14 зүйлийн 2 дахь хэсгийн 4, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 3.2, 3.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Монгол Улсын их сургуулийн албан хэрэгцээнд зориулан өөрийн хөрөнгийн эх үүсвэрээр 2022 онд нийт 7,622,648,625.00 (долоон тэрбум зургаан зуун хорин хоёр сая зургаан зуун дөчин найман мянга зургаан зуун хорин таван) төгрөгт багтаан барилга, байгууламж олж авахыг зөвшөөрч санхүүжилт, худалдан авах үнийн дээд хязгаарыг хавсралтаар баталсугай.

2.Монгол Улсын их сургуулийн захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Очирхуягт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.

2.1.Хөрөнгө худалдан авах ажлыг холбогдох хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2023 оны 1 дүгээр сард багтаан ирүүлэх.

3.Худалдан авсан хөрөнгийг бүртгэлд тусгах, энэ тогтоолын биелэлтийг тайлагнах ажилд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т даалгасугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТЭСИЙН ДАРГА  Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 02 дугаар сарын 2-ны өдрийн 77 дугаар тогтоолын хавсралт



**МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛИЙН ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭР  
2022 ОНД АВАХ БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЖАГСААЛТ**

№	Эргэлтийн бус хөрөнгийн төрөл, нэр	Хэмжих нэгж	Барьж эхэлсэн (эхлэх) он	Нийт төсөвт өртөг (төгрөг)	2022 онд зарцуулах санхүүжилтийн дээд хязгаар (төгрөг)
<b>1.1. Барилга байгууламж, их засвар, өргөтгөл (2020-2021 онд эхэлсэн 2022 онд үргэлжлэх)</b>					
1	Барилгын хөрөнгө оруулалт-хичээлийн 7 байр зураг төсөл	ш	2020	104,000,000.00	83,200,000.00
2	Барилгын хөрөнгө оруулалт-хичээлийн 7 дугаар байр	ш	2021	882,670,000.00	2,458,527,200.00
3	Барилга хөрөнгө оруулалт-хичээлийн 8-р байр зураг төсөв	багц	2021	7,000,000,000.00	120,000,000.00
4	Барилгын хөрөнгө оруулалт-хичээлийн 8-р байрны газар чөлөөлөлт	ш	2021	34,000,000.00	34,000,000.00
<b>2021 оноос шилжиж ирсэн хөрөнгө оруулалт</b>				<b>8,020,670,000.00</b>	<b>2,695,727,200.00</b>
<b>1.2. Барилга байгууламж (2022 онд хэрэгжиж эхлэх)</b>					
1	Барилга хөрөнгө оруулалт-хичээлийн 8-р байрны зураг төсөл, төсөв	багц	2022	295,586,445.00	295,586,445.00
2	Барилгын хөрөнгө оруулалт-хичээлийн 8-р байрны геологи геодези	ш	2022	36,850,000.00	36,850,000.00
3	Барилгын хөрөнгө оруулалт-хичээлийн 8-р байрны барилгын барилга <i>нийт төсөвт өртөгт үнийн өсөлт тооцов.</i>	ш	2022	12,361,530,000.00	2,753,012,180.00
4	Барилгын хөрөнгө оруулалт-хичээлийн 7 дугаар байрны барилга	ш	2022	8,826,700,000.00	1,841,472,800.00
<b>2022 онд эхлэх хөрөнгө оруулалт</b>					<b>4,926,921,425.00</b>
					<b>7,622,648,625.00</b>
<b>НИЙТ ДҮН</b>				<b>(долоон тэрбум зургаан зуун хорин хоёр сая зургаан зуун дөчин найман мянга зургаан зуун хорин таван)</b>	